

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРЭХ СУМ

2020 оны 02 дугаар сарын 07

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДҮЁАҮӨҮӨ НОИУИ “КАМЕРЖУУЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ” ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

(ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР БАРАА
ХУДАЛДАН АВАХАД АШИГЛАНА)

Тендер
шалгаруулалт/ гэрээний нэр:
“Камержуулалтыг нэмэгдүүлэх”

Тендер
шалгаруулалт/
гэрээний дугаар:/ХА/2020/02

Дорноговь аймаг, Дэлгэрэх сум
2020 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

[Дорноговь аймгийн Дэлгэрэх сум] нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **[Камержуулалтыг нэмэгдүүлэх¹]** нийлүүлэх суурьлуулах тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **[2020 оны 02 дүгээр сарын 14-ний өдрийн 10:00]**-аас өмнө **[tender.gov.mn]** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **[2020 оны 02 дүгээр сарын 14]**-ны өдрийн **[10:30 минутанд]**¹-т нээнэ.

Дотоодны давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дорноговь аймаг Дэлгэрэх сум
Засаг даргын Тамгын газар
Газрын даамал И.Болортуяа
Утас: **96671661**
Засаг даргын орлогч Р.Сосорбарам
Утас: **91103933**

¹ Тендерийг хүлээж авах эцсийн хугацааг дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: БХБСайдын Барилга угсралтын ажлын</p> <p>БА-6.3 Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт,</p> <p>БА-6.4 барилга байгууламжийн дотор холбоо, дохиолол, интернет сүлжээ, , гал унтраах болон галын аюулгүй дохиололын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралтын хүчинтэй хугацаа дуусаагүй барилгын тусгай зөвшөөрөлтэй, Тусгай зөвшөөрлийн эх хувь / гэрээ болон хавсралтын хамт хүчинтэй/ Хавсралт дээр тайлан татвар төлсөнг гэрчлэх тэмдэглэл тэмдэгтэй байх, Хамгийн багадаа сүүлийн 3 улирал</p> <p>- Гэрэлтүүлэг угсралтын ажлын</p> <p>03.2.1, 0.4-10 Цахилгаан дамжуулах шугам, дэд станц угсралт, засвар түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ, Тусгай зөвшөөрлийн эх хувь гэрээний хамт</p> <p>Тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартайг нотлохын тулд захиалагч дараах нэмэлт нотлох баримтыг тендерийн хамт ирүүлэх:</p> <ul style="list-style-type: none"> - Улсын бүртгэлийн гэрчилгээ эх хувь - Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан /АУДИТ-р баталгаажуулсан/ Эх хувь - Сүүлийн нэг жил буюу 2019 онд тухай ажилтай ижил төстэй камерийн 3 –аас дээш ажил гүйцэтгэсэн байх, Тухай ажлыг нотлох бичиг баримт, Гэрээ, хүлээн авсан акт, Захиалагч, ашиглалгч байгууллагын аль нэгний тухай ажил дууссан тухай тодорхойлолт эх хувь - Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ санал болгож буй үнийн дүнгийн 100%-иас багагүй байх - Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлого санал болгож буй үнийн дүнгийн 100%-иас багагүй байх - Оролцогч компанийн танилцуулга - Ажлын зураг, тоо хэмжээний дагуу тооцсон төсөвтэй, эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулсан байна. /Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсвийн норм үнэлгээгээр тооцно/ Зураг үнэ 500 000 тусгаж ирүүлэх - Ажил гүйцэтгэх нарийвчилсан хугацааны график гарган баталгаажуулж ирүүлнэ. - Харилцагч банкны тодорхойлолт, Харилцдаг бүх банкны /өргүй байх/ Эх хувь - Татварын газрын тодорхойлолт, Цахим системээс авах/өргүй байх/ Эх хувь - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь - Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт Эх хувь

	<ul style="list-style-type: none"> - Ато тээврийн газрын тодорхойлолт - Гэрээг гүйцэтгэх удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл Үүнд: Цахилгааны инженер 1, ХАБЭА-н инженер 1, туслах ажилтан 3-аас дээш байх бөгөөд компаний үндсэн ажилтан байна. Нотлох баримт ирүүлнэ. Иргэний үнэмлэх, дипломын хуулбар, НД-н дэвтэрийн хуулбар ирүүлнэ. НД8 маягтыг 2019 оны 1сараас 2020оны 1 сар хүртэлх тайланг эх хувиар ирүүлнэ. - Машин механизм тоног төхөөрөмжийн судалгааны жагсаалтыг бодит байдлын фото зураг, холбогдох баримт бичгийн хамт ирүүлэх - Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмууд: Авто кран, Үйлчилгээний машин шат, цахилгааны төрөл бүрийн багаж хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгсэлтэй байх - Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан ажлын даалгавар, техникийн нөхцлийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн ажлыг гүйцэтгэн дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ. - Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод, гаргацтай байх шаардлагатай. - ТШӨХ-д шаардсан материалуудын аль нэгийг ирүүлээгүй, Эх хувь гэсэнг хуулбар ирүүлсэн тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно - Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл - Тодорхойлолтууд нь тендер зарласан өдрөөс хойш авсан байна. Баталгаат хугацааны албан бичиг ирүүлэх -
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Үнийн санал, тендерийн материалыг [2020 оны 02 дүгээр сарын 14-ны өдрийн 10:00]-аас өмнө [tender.gov.mn] хаягаар ирүүлнэ.</p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: [Дорноговь аймаг, Дэлгэрэх сум, Хонгор баг, ЗДТГазар]</p> <p>Давхар болон өрөөний дугаар: [Засаг даргын орлогчийн өрөө №4]</p> <p>Огноо: [2020 оны 02 дүгээр сарын 14-ны өдөр]</p> <p>Цаг: [10 цаг 30 минут]</p>
<p>ТӨӨЗ 2.3</p>	<p>Энэ хэсэгт материал шаардахгүй.</p>
<p>ТӨӨЗ 6.2</p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: [Дэлгэрэх сумын камержуулалтын нэмэгдүүлэх ажилд үнийн санал авна]</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт:

№	Материалын нэр	Үзүүлэлт	Тоо хэмжээ
1	Гадаа зориулалтын чиглэлийн камер	<ul style="list-style-type: none"> • Тоон технологи дээр суурилсан байна. • Олон улсын тоон сүлжээний хяналтын камерын нэгдсэн стандарт болох ONVIF стандартыг дэмждэг байна. • Ус чийг, шороо тоос, доргилт, чичиргээнээс хамгаалагдсан олон улсын IP66, IP67 болон түүнээс дээш стандартыг хангасан байна. • RTSP дүрсний протоколыг дэмждэг байх. • IPv4/v6 HTTP, HTTPS, QOS болон бусад сүлжээний протоколуудыг дэмжин ажилладаг байна. • SMPTE 274M стандартыг хангасан буюу 4MP-ээс доошгүй дүрсний нягтралтай байна. • Дүрс хувиргаж сүлжээнд дамжуулах шахалтын горим нь H.265, Motion JPEG (M-JPEG) байна. • 5-аас доошгүй тооны хэрэглэгч зэрэг хандах боломжтой байна. • Хэрэглэгчийн нууц үг. IP хаягийн хязгаарлалт, HTTPS encryption гэх мэт хамгаалалттай байна. • Хяналтын камер нь гудамж талбайд байгаа олон нийтийн хөдөлгөөнийг бүхэлд нь харах боломжтой буюу 3.6mm-96mm байна. • Орчны гэрэлд тохирч ажиллах, автомат функцтэй байна. • Хамгийн бага гэрлийн орчин нь хар цагаан горимд 0.05 люкс эсвэл, өнгөт горимд 0,1люкс эсвэл түүнээс доош байна. 	27 ш
2	Гадаа зориулалтын хөдөлгөөнт камер PTZ 360	<p>Тоон технологи дээр суурилсан байна. 360 градус эргэдэг 30xZoom татах</p> <ul style="list-style-type: none"> • Олон улсын тоон сүлжээний хяналтын камерын нэгдсэн стандарт болох ONVIF стандартыг дэмждэг байна. • Ус чийг, шороо тоос, доргилт, чичиргээнээс хамгаалагдсан олон улсын IP66 болон түүнээс дээш стандартыг хангасан байна. • RTSP дүрсний протоколыг дэмждэг байх. • IPv4/v6 HTTP, HTTPS, QOS болон бусад сүлжээний протоколуудыг дэмжин ажилладаг байна. • SMPTE 274M стандартыг хангасан буюу 5MP-ээс доошгүй дүрсний нягтралтай байна. • Дүрс хувиргаж сүлжээнд дамжуулах шахалтын горим нь H.265, Motion JPEG (M-JPEG) байна. • 5-аас доошгүй тооны хэрэглэгч зэрэг хандах боломжтой байна. • Хэрэглэгчийн нууц үг. IP хаягийн хязгаарлалт, HTTPS encryption гэх мэт хамгаалалттай байна. • Хяналтын камер нь өрөөнд байгаа олон нийтийн хөдөлгөөнийг бүхэлд нь харах боломжтой буюу 3.6mm-96mm байна 	2ш
3	Гадаа зориулалтын гэрлийн гялбаа бууруулагчтай	<p>Машины хурц гэрлийг унагаж, номерыг гялбааг гаргах, номер харах зориулалтын камер</p> <p>Тоон технологи дээр суурилсан байна.</p> <ul style="list-style-type: none"> • Олон улсын тоон сүлжээний хяналтын камерын нэгдсэн стандарт болох ONVIF стандартыг дэмждэг байна. • Ус чийг, шороо тоос, доргилт, чичиргээнээс хамгаалагдсан олон улсын IP66 болон түүнээс дээш стандартыг хангасан байна. • RTSP дүрсний протоколыг дэмждэг байх. • IPv4/v6 HTTP, HTTPS, QOS болон бусад сүлжээний протоколуудыг дэмжин ажилладаг байна. • SMPTE 274M стандартыг хангасан буюу 4MP-ээс доошгүй дүрсний нягтралтай байна. 	6ш

	камер	<ul style="list-style-type: none"> • Дүрс хувиргаж сүлжээнд дамжуулах шахалтын горим нь H.265, Motion JPEG (M-JPEG) байна. • 5-аас доошгүй тооны хэрэглэгч зэрэг хандах боломжтой байна. • Хэрэглэгчийн нууц үг. IP хаягийн хязгаарлалт, HTTPS encryption гэх мэт хамгаалалттай байна. • Хяналтын камер нь өрөөнд байгаа олон нийтийн хөдөлгөөнийг бүхэлд нь харах боломжтой буюу 3.6mm- 96mm байна 	
4	Бичигч төхөөрөмж	<ul style="list-style-type: none"> • NVR, 8-32 port оролттой. • Digital zoom, audio video hdmivga output • Тоон технологи дээр суурилсан байна. • Олон улсын тоон сүлжээний хяналтын камерын нэгдсэн стандарт болох ONVIF стандартыг дэмждэг байна. • RTSP дүрсний протоколыг дэмждэг байх. • IPV4/V6 HTTP, HTTPS, QOS болон бусад сүлжээний протоколуудыг дэмжин ажилладаг байна. • Дүрс хувиргаж сүлжээнд дамжуулах шахалтын горим нь H.264/ H.265/ H.265+ Motion JPEG (M-JPEG) байна. • 5-аас доошгүй тооны хэрэглэгч зэрэг хандах боломжтой байна. • Хэрэглэгчийн нууц үг. IP хаягийн хязгаарлалт, HTTPS encryption гэх мэт хамгаалалттай байна. 	2ш
5	Хард диск	HDD 8000GB	1-2ш
6	Нарны толь	540x630x13mm 50W-65W	1ш
7	Battery	12v 20a	1ш
8	Антенн	<p>Wifi Антенны үзүүлэлт: 10km range 5GHz to 433bps, 11AC</p> <p>IP64 усны хамгаалалттай</p> <p>16dbi directional antenna</p> <p>AP, station, WISP etc operating mode supported up to 60 meters of flexible deployment included PoE injector</p>	25ш
9	Хяналтын дэлгэц	Сайн чанарын Өнгөт 37 inch-ын дэлгэц	2ш
10	Свич	Сүлжээний 4, 8, 16-н тус2 үүргэй байна	25ш
11	Тэжээлийн утас	Зэс голтой	500м
12	Тоолуур	220V электрон тоолуур (шаарлагатай байршилд байршуулах)	25
13	Хар хоолой	Шаарлагатай байршилд байршуулах	3Боодол
14	Сүлжээний кабель	stp cat6	1000м
15	Агаарын кабель	2x2 сэб	500м
16	Сүлжээний толгой	Шаарлагатай байршилд байршуулах	-
17	Цахилгааны самбар	Цахилгааны самбар	10
18	Камерын шон	Шинээр тавигдах байршилд 8 м өндөр шон 20-15 см-ын радиустай	8

2. **Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана. Эсхүл [Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.] гэж бичнэ
3. **Баглаа, боодол:** [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн эрүүл ахуйн горимыг сахиж хайрцаг сав баглаа боодол эвдэрч хэмхэрээгүй байх.]
4. **Бараа хүргэх газар:** [Барааг Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын ЗДТГазар, бараа хүлээн авах комисст]
5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:** [Барааг гэрээнд заасан хугацаанд ирүүлж суурьлуулна]

Боловсруулсан:Газрын даамал

Болортуяа

И.Болортуяа



Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|----------------------------------------------------|-------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан моо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[100]²** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)³ 9.1. Алданги оногдуулах хувь: **[1 Хувь]**
- Алдангийн нийт дүн: **[10 хувь]**

² Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

³ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁵;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

⁴ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁵ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]